



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/31

Бодь

Сумын хэмжээнд 2022 оны нэгдүгээр  
ээлжийн цэрэг татлагын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын “Цэргийн жинхэнэ албаны халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай” 2022 оны н/67 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/193 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2022 оны ээлжит цэрэг татлага, цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах, цэргийн гэрээт албанд элсүүлэх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр зохион байгуулсугай.

2. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт даалгах нь:

а. Цэрэг татлагын ажлын хэсгийн гишүүдэд ажил үүргийн хуваарийг тогтоон, цэрэг татлагын ажилтай холбоотой хууль, эрх зүйн мэдээлэл, тухай ажлыг гүйцэтгэх онцлогийн талаар зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах

б. Цэрэг татлагын үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх.

4. Цэрэгт татагдагчдыг короновирус (covid-19)-ээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалалтыг дэглэмийг сахиулах бүх талын арга хэмжээ авч цэрэг татлагын байрыг ариутгуулах, эрүүл мэндийн үзлэг явуулах шаардлагатай байр, эм эмнэлгийн багаж төхөөрөмжөөр хангаж, төрийн үйлчилгээг үзүүлэх;

642201041

5. Гэмт хэргийн холбогдолтой болон хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байгаа иргэдийн судалгааг гаргах,

6. Цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зарлан дуудах мэдэгдэл аваад тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг эрэн сурвалжилж татлагаар оруулах бүх талын арга хэмжээ авахыг хэсгийн төлөөлөгч (М.Цэнд-аюуш), цагдаа (Э.Даваацэрэн) нарт даалгасугай.

а. Сумын цэрэгт татагдах 18-25 (1997-2004 он) залуучуудад нэрийн бүртгэлийн дагуу цэргийн жинхэнэ албаны зарлан дуудах мэдэгдлийг нэг бүрчлэн гардуулж, тооцоог тасалбараар аймгийн Цэргийн штабтай хийх.

б. Цэргийн насны залуучуудыг цэрэг татлагын товчоогоор бүрэн хамруулах арга хэмжээ авч ажиллах.

в.Цэргийн насны залуучуудыг цэрэг татлагаар орохоос өмнө эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамруулсан байх.

г. Цэрэг татлагын товчоогоор ороогүй цэргийн үүрэгтэнг эрэн сурвалжилж шалтгааныг тодотгон хүн тус бүрийн нэрээр Цэргийн штабтай тооцоог хийх.

д. Цэргийн насны мөнгөн төлбөр тогтоогдсон иргэдийг цэрэг татлагын товчоогоор бүрэн хамруулах


7. Цэргийн жинхэнэ албаны татлагаар зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр, товлосон газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй иргэдийн судалгааг аймгийн Цэргийн штабт хүргүүлэх

8. Цэрэг татлагын зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэцэцэг), Нягтлан бодогч (Б.Батбаяр) нарт зөвшөөрсүгэй.

9. Шаардагдах хөрөнгийн тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.


10. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 03 дүгээр сарын 05 –ны өдрийн А/31 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт




Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах  
ажлын хэсгийг бүрэлдэхүүн

|                      |  |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч | Т.Эрдэнэцэцэг (Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  |
| Гишүүдэд             | М.Оюунбилэг (Архив, бичиг хэргийн эрхлэгч)<br>О.Баасанбат (Нийгмийн даатгалын байцаагч)<br>Ц.Цэрэнхүү (Эрүүл мэндийн төвийн дарга)<br>Т.Эрдэнэтуяа (Лаборант)<br>С.Оюунбилэг (Насан туршын боловсролын арга зүйч)<br>Т.Цэнд-Аюуш (Соёл, спортын төвийн дарга)<br>М.Цэнд-Аюуш (Хэсгийн төлөөлөгч)<br>Э.Даваацэрэн (цагдаа)<br>Ж.Лхагвасүрэн (1 дүгээр багийн Засаг дарга)<br>Д.Наранбаатар (2 дугаар багийн Засаг дарга)<br>У.Батцэцэг (3 дугаар багийн Засаг дарга)<br>Б.Мөнхбат (4 дүгээр багийн Засаг дарга)<br>Б.Ганцэцэг (5 дугаар багийн Засаг дарга) |
| Нарийн бичгийн дарга | Н.Сумъяа (Засаг даргын орлогч)   |

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05 ны өдрийн 1/31 тоот захирамжийн 2 дугаар хавсралт



ЦЭРЭГ ТАТЛАГЫН БАЙР ЗАСАХАД ШААРДАГДАХ  
ХӨРӨНГИЙН ТООЦОО

| Д/Д | Бэлтгэх зүйл  | Хэмжээ                 | Дүн     |
|-----|---|------------------------|---------|
| 1   | Хулдаасан хэвлэл                                      | 3*2                    | 72.000  |
| 2   | Цайны зардал  | 1                      | 40.000  |
| 3   | Овоотын цэргийн ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлд тусламж | 1                      | 100.000 |
| 4   | Гарын авлага материал бэлтгэх                         | Өнгөт хар бичгийн цаас | 100.000 |
| 5   | Нийт дүн  | 5                      | 312.000 |

oOo